

ГАРЧИГ

1.	Төслийн товч тодорхойлолт	3
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2	Ордын нөөц	4
1.3	Уурхайн ашиглалт, хүчин чадал, төлөвлөлт	4
1.4	Дэд бүтэц, уурхайн барилга байгууламж	5
2.	<i>ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	6
3.	<i>СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	8
3.1	Агаарын чанарын чиглэлээр	8
3.2	Усан орчны чиглэлээр	10
3.3	Хөрс, ургамал, амьтны чиглэлээр	11
3.4	Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлууд	15
3.5	Дүйцүүлэн хамгаалах ажлын биелэлт	17
3.6	Нөхөн сэргээлтийн биелэлт	19
3.7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	21
3.8	Осол эрсдэлийн менежментийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд	25
3.9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	27
3.10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	29
4.	<i>ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ</i>	31
5.	<i>БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ</i>	34
	<i>ДҮГНЭЛТ</i>	35

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил	8
Хүснэгт 2.	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	10
Хүснэгт 3.	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	11
Хүснэгт 4.	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	13
Хүснэгт 5.	Тэрбум мод хөтөлбөрийн биелэлт	15
Хүснэгт 6.	Дүйцүүлэх хамгаалах ажлын биелэлт	17
Хүснэгт 7.	Нөхөн сэргээлтийн биелэлт	19
Хүснэгт 8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	21
Хүснэгт 9.	Осол эрсдэлийн менежментийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын биелэлт	25
Хүснэгт 10.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	29
Хүснэгт 11.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	31
Хүснэгт 12.	2025 онд зарцуулсан төлбөр	34

ЗУРАГ

Зураг 1.	Төслийн талбайн байршлын тойм зураг	3
Зураг 2.	Авто машины төлбөр төлсөн баримт	9
Зураг 3.	Шүүрлийн усны тоолуур	10
Зураг 4.	Бие засах газрын байршлыг сольж шинээр доторлов /2025.10 сар /	12
Зураг 5.	ШТС-ын суурийг цементлэв /05 сарын 26/	12
Зураг 6.	Авто зогсоолын суурийг цементлэв	13

**“ӨМНӨ БАГА ЧУЛУУ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Зураг 7. Ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа /2025.08 сар/ унтраах багаж хэрэгслийн зураг	Зураг 8. Гал	14
Зураг 9. Мод тарьж байх үеийн зураг /2025. 06 сар/		15
Зураг 10. Модны ургалт болон бордоо		16
Зураг 11. Тэрбум модны ургалт /2025. 08 сар/		16
Зураг 12. Дүйцүүлэн хамгаалах ажил		18
Зураг 13. Техникийн нөхөн сэргээлтийн үеийн зураг		19
Зураг 14. Нөхөн сэргээлт хүлээлгэж өгсөн акт		20
Зураг 15. Хог хаягдлын цэг байгуулсан байдал		22
Зураг 16. Их цэвэрлэгээ хийгдэж буй байдал		23
Зураг 17. Хог ангилан ялгаж буй байдал		24
Зураг 18. Сумын эмнэлэгтэй хамтран ажилчдыг эмнэлгийн анхан шатны үзлэгт хамруулав /2025 оны 4-р сар/		25
Зураг 19. Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт тогтмол явуулж байв /2025 оны 4 сар/		26
Зураг 20. Хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгсэл авсан байдал		26
Зураг 21. Тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал		27
Зураг 22. Үерийн усны далангийн засвар шинэчлэлийн ажил		28
Зураг 23. Тойг багийн хуралд уурхайн үйл ажиллагаагаа танилцуулав /2025 оны 05 сар/		29
Зураг 24. Сум, Багийн иргэдийн төлөөлөл нийт 19 хүн уурхайн үйл ажиллагаатай танилцав /2025 оны 09 сар/		30
Зураг 25. Орчны хяналт шинжилгээний үеийн ажлын явц		33

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Газрын гэрээ	37
Хавсралт 2. Авто машины албан татвар төлсөн баримт	37
Хавсралт 3. Ус ашиглах дүгнэлт	38
Хавсралт 4. Усны төлбөр төлсөн баримт	39
Хавсралт 5. Анхны түргэн тусламжийн 63 нэр төрөл бүхий даралтын аппарат, тариур, дуслын систем болон эмийн жагсаалт	39
Хавсралт 6. Уст цэг ашиглах гэрээ	40
Хавсралт 7. Орчны хяналт шинжилгээний хүрээнд хийгдсэн дээжний хариу	41
Хавсралт 8. Уурхайн нөхөн сэргээлтийн маркшейдэрийн хэмжилт	42

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: Өмнө бага чулуу хайлуур жоншны орд


Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Мандах дорнын жонш” ХХК

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Барилгачдын талбай, Макс тауэр цамхаг 9 давхар, 904 тоот Утас: 91924007, 70147777.

Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн дугаар: Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011300024, Регистрийн дугаар: 5497272.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл: “Өмнө бага чулуу” нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн АМГ-ын ГУУКХ-ийн даргын 301 тоот шийдвэрээр MV-021637 тоот 219.4 га талбай бүхий Ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Мандах дорнын жонш” ХХК-д 30 жилийн хугацаагаар олгосон.

Төслийн талбайн байршил: Өмнө бага чулуу хайлуур жоншны орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 450 км, Алтанширээ сумаас зүүн хойш 30 км-т, Бага чулуу уулын орчимд. Өмнө бага чулуу хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 450 км, Дорноговь аймгийн Алтанширээ сумаас зүүн хойш 30 км-т Улаанбаатар Сайншандын чиглэлийн хатуу хучилттай замын зүүн талд, номенклатурын хувьд L-49-78 нэрлэвэрт байршдаг.



Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг

1.2 Ордын нөөц

Төсөл хэрэгжүүлэгч нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд өөрийн хөрөнгөөр нарийвчилсан хайгуул хийж, хайгуулын ажлын үр дүнд жоншны нөөцийг ЭБЭХЯ, ЭБМЗ-н 2020 оны 07-р сарын 08-ны (дүгнэлтийн дугаар ХХ-10-12) өдрийн хурлаар хэлэлцэн бодитой В зэргээр 101.703.56 тн хүдэр, хүдрийн дундаж агуулга 40.6%-тай хайлуур жонш 41.293 тн, боломжтой С зэргээр 48.173.60 тн хүдэр, хүдрийн дундаж агуулга 42.85%-тай хайлуур жонш 20,643 тн, нийт В+С зэргээр 149.877.17 тн хүдэр, хүдрийн дундаж агуулга 41.32%-тай хайлуур жонш 61.936 тн гэж Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн н/66 тоот тушаалаар ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн. Орд нь газрын гадаргуун хувьд бага хэрчигдэлтэй намхан уулс, толгод, гүвээрхэг гадаргуу бүхий тачир ургамлын бүрхэвчтэй ой мод, гол горхигүй, хуурай эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд оршдог.

Энэ орд нь хүдрийн биетийн тогтцын хувьд ашигт малтмалын ордын ангиллын дагуу II бүлэгт багтах ба судал хэлбэрийн хүдрийн биет бүхий суналын дагуу урт 260 м, гүндээ 130 м хүртэл гүн, гадаргууд 1.0-3.0 м хүртэл өргөнтэй гүнд 1.1-3.2 м хүртэл зузаантай, хүдрийн биетүүдийн дундаж зузаан 2.01 метр, хүдрийн биетийн дундаж уналын өнцөг 790, хүдрийн биетийн дундаж агуулга 41.32% тус тус байна.

Уурхай ашиглах ТЭЗҮ-ийг зөвхөн “В” зэрэглэлийн нөөцөд тулгуурлан, жилийн хүчин чадлыг 45.000 тн/жил хүдэр олборлохоор боловсруулсан байна. Мөн ил уурхайн ашиглалт эхний жилд явагдаж дуусах ба үргэлжлүүлэн далд уурхайн үндсэн малталт, бүтээн байгуулалтын ажлыг хийж, 2 дах жилээс далд уурхайн олборлолт ашиглалтыг хийхээр тооцжээ.

Уулын ажил нь улирлын чанартай дулааны улиралд явагдах бөгөөд жил бүр 4 сарын 15-аас 10 сар дуустал 7 сар ажиллах ба ажиллах горим нь хоногт нэг ээлж 12 цагаар ажилладаг.

Далд Уурхай нь 2 ш босоо амтай, төмөр хийц бүхий бэхэлгээтэй, уурхайн 1-р хэсгийн Ашиглалтын гол босоо амуудаар ажилчдыг оруулж гаргах, хүдэр, хоосон чулуулаг, материал болон тоног төхөөрөмж, сэлбэг материал оруулах, уурхайг агааржуулах зэрэг туслах чанарын үүрэгтэй. Агааржуулалтын 3 амтай, эдгээр нь газрын гадаргуугаас дээш 0.50м-ийн өндөртэй бүхий тоосгон хашлага бүхий бэхэлгээтэй, агаар оруулж гаргах үүрэгтэй, Өргөх систем нь 1 клетьтэй, цамхаг хэлбэрийн дан тросст өргөгч машин, троссон чиглүүлэгч замтай.

1.3 Уурхайн ашиглалт, хүчин чадал, төлөвлөлт

Уурхайн олборлолтыг ордын геологийн тогтоц, уул техникийн нөхцөлөөс хамааран ил аргаар +1130 м-ийн түвшин хүртэл авто тээвэртэй гадаад овоолготой, далд уурхайг хүдрийн биетийн унал, биетийн зузаан, чулуулгийн бат бэхээс хамааран хүдэр хоршоолох ашиглалтын системээр олборлолтыг хийн, улирлын чанартай ажиллаж байна. Уурхайн төслийн хүчин чадал нь жилийн 45.0 мян.тн.

Далд уурхайн хувьд 2023-2024 онуудад үндсэн малталт болон бэлтгэл малталтыг нэвтэрсэн бөгөөд 2025 онд +1086-1126 м-ийн түвшинд олборлолт хийхээр төлөвлөсөн ба 19.21 мян.тн хайлуур жоншны хүдэр олборлосон. Далд уурхайд нураагдсан хүдэр болон хоосон чулууг ачих ажилд ZWT-60A маркийн 0.1 м3 утгуурын багтаамжтай ачигч машин, YA-26 маркийн 0.8 м3 тэвшний багтаамж бүхий өөрөө буулгагч 3 дугуйт тээврийн машин ашиглаж байна.

Уурхай нь 2025 онд далд уурхайгаас 35.93% агуулгатай 68.46 мян.тн хүдрийг олборлохоор төлөвлөсөн ба нийт 43.34 мян.тн жоншны хүдэр олборлосон.

1.4 Дэд бүтэц, уурхайн барилга байгууламж

Уурхай нь дэд бүтцийн хувьд “Өмнө бага чулуу” хайлуур жоншны ордоос баруун тийш 20 км зайд Иххэт сумаас Алтанширээ сум хүртэл татсан 35 кВ-н өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам өнгөрдөг ба засаг захиргааны нэгжийн хувьд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 450 км, Алтанширээ сумаас зүүн хойш 30 км, Иххэт-Алтанширээ чиглэлийн сум хоорондын замаас зүүн тийш 15 км зайтай оршдог.

Өмнө бага чулуу хайлуур жоншны ордын Далд уурхайн цахилгаан эрчим хүчийг БНХАУ-д үйлдвэрлэсэн QSY-500GF маркийн 500 кВт-ын чадалтай, тосгоныг QSY-100GF маркийн 100 кВА чадалтай дизель генератораар цахилгааныг хангаж байна. Уурхайн ажилчдын гэрийг галлагаагаар халааж, уурхайн захиргаа болон гал тогоо, засварын газрын барилга байгууламжуудын халаалтыг нам даралтын зуухаар халаадаг. Уурхайн оффисын байр, гал тогоо, амралтын байр зэрэг уурхайн халаалт шаардлагатай бүхий л хэрэглэгчдийг хүйтний улиралд халааж дулааны улиралд халаалтыг зогсоодог.

Уурхайн барилга байгууламжийн хувьд уурхайн хотхонд дунджаар 60 хүн амьдрах ажилчдын амрах байр, хотхоны гал тогоо, халуун ус, оффисын байр, засварын газар, машины зогсоол, граж, шатахуун түгээгүүр, далд уурхайн гол босоо ам, агааржуулалтын босоо ам болон ил уурхайн карьер, бүхэллэг жонш ялгах зэрэг байгууламжаас бүрдэнэ. Уурхайн хотхон нь ордын баруун зүгт 800 м зайд ажилчдын амьдрах гэр, захиргааны байр, ажилчдын цайны газрын байр болон угаалгын газраас бүрдэнэ. Уурхайн ажиллагсдыг ахуйн зориулалтаар бүрэн тоногдсон монгол гэрт байрлуулах бөгөөд 1 гэрт 5 хүн байрладаг.

Уурхайн унд ахуйн усыг малчдын Цагаан дэл гүний худгаас, технологийн болон ногоон байгууламжийн усалгааг шүүрлийн усаар хангаж байна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газар зүй: Ашигт малтмалын ашиглалтын талбай нь газар зүйн бүсийн ангиллаар хээр талын бүсэд хамрагдана. Тус нутагт өндөр уул нуруу, гол мөрөн байхгүй. Газрын гадаргуу нь жижиг гүвээ, толгод, тэгшивтэр тал гадаргаас бүрдэнэ. Талбайн төв хэсгээр жижиг гүвээ, толгодууд орших ба тэдгээр нь сулавтар хэрчигдэлтэй, жижиг гуу жалгуудтай. Харин талбайн баруун хойд ба зүүн өмнөд хэсгээр томоохон хөндий, талууд оршино. Талбайн хэсэгт орших хамгийн өндөр цэг нь далайн төвшнөөс дээш 1450 м-т өргөгдсөн ба хамгийн нам дор цэг нь 1130 м-ийн уулс хоорондын жижиг хөндий болно. Толгодын харьцангуй өндөр 40-70 м-т хэлбэлзэнэ. Судалгааны талбайд ой мод, намаг шавар байхгүй

Уур амьсгал: Судалгааны талбай нь жилийн дөрвөн улирал ээлжлэн солигддог эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын температурын зөрүү их. Өвөл нь -37.5С хэм хүртэл хүйтэрнэ. Зун хамгийн их халж +34.9-өөс +40С хэм хүрнэ. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 277 мм бөгөөд үүний 70 гаруй хувь нь зуны улиралд бууна. Жил бүрийн 10-р сарын сүүл үеэс цас орж хүйтний улирал эхэлдэг. Салхины хурд 3-5 м/сек-ээс 18 м/сек хүрнэ. Заримдаа түүнээс ч хүчтэй шороон шуурга шуурна.

Хөрсөн бүрхэвч: Тус газар нутаг нь хөрс газарзүйн мужлалаар Монголын Дорнод хэсгийн цайвар хүрэн, давсархаг хөрс, элс бүхий Дорнод хотгорын тойрогт багтана. Нийт газар нутаг нь хотгор, түүний дотор жижиг хонхруудтай бөгөөд эдгээрийг тусгаарласан гүдгэрүүдтэй учраас нийтдээ ухаа гүвээт талын хотгор гүдгэр ноёрхоно. Үнэмлэхүй өндөр нь 1115-1128 м орчим байна. Газар нутгийн рельеф нь жижиг овоо бүхий тэгш тал газар, толгодоос бүрдэх ба уул-геологийн тааламжтай нөхцөлд оршино. Агь хазаар өвс-хялганат хээр энд зонхилох боловч ургамлын бүрхэвч сийрэг. Тал хөндийн хөрсний хүрэн хөрсний хэв шинж бүхий цайвар хүрэн хөрсний дэд хэв шинжит хөрс голлон тархана. Механик бүрэлдэхүүнээр хөнгөн шавранцар, элсэнцэр, элсэрхэг хөрс байна. Бидний судалгаа явуулсан нутгийн ухаа гүвээ, нам уулс нь далайн түвшнээс дээш 1001-1112 м-ийн өндөрт өргөгдсөн, дэрстэй хөндий арай нам дор газар байрлажээ.

Ургамлан нөмрөг: Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар А.А.Юнатовынхаар /1950/ Евразийн хээрийн мужийн Умард говийн цөлөрхөг хээрийн хошууны Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт; Н.Өлзийхутагийнхаар Голарктикийн их мужийн Төв Азийн хээр, цөлийн дэд мужийн Монголын хээр, цөлийн хошууны Умард говийн цөлөрхөг хээрийн дэд хошууны Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна. Дорноговийн цөлөрхөг хээрийн тойргийн ургамлын аймаг нь жинхэнэ говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрддэг онцлогтой. Тус сумын нутаг ботаник газар зүйн мужлалаар дээгүүр, Монголын хээрийн тойргийн Нялгын районд хамаарна. Уулын хээрт: Цахилдаг, алаг өвст, хиаг хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно. Тал хээрт: Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний төрлийн ургамал зонхилно. Мөн гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана, адамсын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботууль ургамал зонхилон ургадаг байна. Сумын нийт бэлчээрийн 4.5 хувь нь цэвэр бэлчээр, 59 хувь нь сөөгт бэлчээр, 22 хувь нь чулуурхаг бэлчээр, 14.5 хувь нь довонтой бэлчээр байна. Эмийн ургамлаас: Юлдэн тарваган шийр, өргөст сарнай, нохойн хошуу, говийн ганга, таван салаа, царван, хөх дэгд, шар дэгд, цөс өвс, арц, банздоо, бошго, сөд, соргол зэрэг олон зүйлийн эмийн ургамал ургадаг.

Гадаргын ус: Судалгааны талбай түүний дүүрэг нь усан хангамж муутай, үндсэндээ гадаргын ус байхгүй дүүрэгт хамрагддаг. Цөөн тооны булаг нь гадаргад хагарлын бүсээр хянагдсан булгуудаар тэжээгдэх бөгөөд зуны улиралд буух хур тунадасны хэмжээтэй шууд холбоотой. Ихэнх хур тунадас 7-8-р сард бороо хэлбэрээр орно. Түр зуурын урсац бүхий цөөн тооны гол дулааны улиралд хур багатай жил шургаж усгүй сайрууд болдог. Эдгээр голуудын ус сайтай байх үеийн урсгалын урт 17521.28-33826.41 м байдаг гэж тэмдэглэгдсэн байдаг. Алтанширээ сумын нутагт 2 булаг тэмдэглэгдсэн байх ба булгийн ус нь тунгалаг, өнгөгүй, үнэргүй, эвгүй амтгүй учраас оршин суугчид ахуйн хэрэгцээнд ашиглаж ирсэн байдаг. Тус дүүргийн томоохон хөндийнүүдэд Цагаан нуур, Улаан нуур зэрэг нуур тойрмууд үүсэж тогтсон. Нуурууд нь зөвхөн борооны улиралд буусан хур тунадсаар тэжээгдэнэ. Бусад хуурай улиралд ширгэж хатсан байдалтай байдаг. Нууруудын хүчтэй ууршилтын үр дүнд давсны хуримтлал буй болдог. Нуурын эрэг орчмоор хужир үүснэ.

Амьтны аймаг: Төсөл хэрэгжих талбайн Төв Азийн хуурай гандуу бүс нутагт хамаарах Умард говийн цөлөрхөг хээр, Дорнод говь, Дорнод Монголын талархаг хялганат хээрийн олон ялгаатай экосистемийг дамнан баригдахаар төлөвлөгдсөн байна. Амьтны аймаг нь Монгол орны хэсэгт хамаарах Төв Азийн хуурай гандуу бүс нутгийн түгээмэл шинжийг илэрхийлэх ба энэ нутагт чоно, үнэг, хярс, бор туулай, хүрнэ, мануул, цагаан зээр, тарвага зэрэг ан амьтан элбэг тааралдах ба сүүлийн жилүүдэд байгалийн хувьсан өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас тарвага, цагаан зээр зэрэг агнуурын ан амьтад эрс ховордсон байна. Жигүүртэн шувуу: Махчин шувууд: Энэ төрлийн шувуудаас Алтан ширээ сумын нутаг дэвсгэрт бүх төрлийн бүргэд, шилийн сар, идлэг шонхор, начин шонхор, зээрд шонхор, тас, элээ, шар шувуу зэрэг. Бусад элбэг шувууд: Хөхвөр тагтаа, соотон гувайлга, хотны бүгээхэй, хэрээ, бөвөөлжин өвөөлж, болжморууд, улаавар бужмаг, ногтруу, тольт дунхай зэрэг шувуудаас гадна агнуурын шувууд болох дагуурын ятуу, цагаан ятуу, тоодог шувууд тааралдана.

Нийгэм эдийн засаг: Дорноговь аймаг нь 109.5 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй 14 сум, 65 багтай. Хэрэглээний бүсчлэлээр зүүн бүст хамаарна. Дорноговь аймаг Монгол орны зүүн өмнөд хязгаарт урд талаараа БНХАУ-тай хил 600 км-ээр хиллэдэг. Улс дотор Өмнөговь, Сүхбаатар, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай хиллэдэг. Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Аймгийн хэмжээнд нийт хүн амын тоо 71.0 мян орчим бөгөөд гол тэнхлэг замын дагуу тус аймгийн бүх сумын 42.8 хувь, хүн амын 61 хувь нь оршин сууж байна. Сумын хэмжээнд нийт 14 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж, 9.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж орон нутгийн хэрэгцээнд нийлүүлж байгаа ба цаашид ойрын сумд болон аймгийн төвд нийлүүлэх зорилготой ажиллаж байна. Сумын нийт аж ахуйн нэгж байгууллага, хувиараа бизнес эрхлэгчид, малчид, иргэд орон нутагт 56.6 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Агаарын чанарын чиглэлээр

Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудыг дараах хүснэгтэд үзүүлэв. Үүнд:
Уурхайн үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлж ажилласан.

Хүснэгт 1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил

Д. Д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх	Компанийн захирал	Уурхайд ажиллаж байгаа машин техникийн бүрэн бүтэн байдлыг ханган ажилласан. 250 мот/цаг тутамд нийт 2 тээврийн хэрэгслүүдийн масло, маслоны шүүр, агаар болон, түлшний шүүрүүдийг байнга сольж байсан. Зардал нь ашиглалтын зардалд орсон болно.
2	Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.		Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг уурхайн шимт хөрсний овоолго, хотхон, засварын талбай, зам зэрэг цэгүүдэд 8, 11-р сард “Ногоон Эко Мандала” ХХК-р хийлгэсэн. Дээжний хариуг хавсаргасан бөгөөд тус хариугаар стандартаас давсан үзүүлэлтгүй.
3	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлсөн. Нийт уурхайн үйлчилгээний 2 машин дээр агаарын бохирдлын төлбөр, татвар 785838 төгрөг төлсөн /Зураг 2/
Нийт			785.8 мян.төгрөг

Төлбөрийн баримт

Smartsag.mn-ээр тээврийн хэрэгслийн төлбөр төлсөн танд баярлалаа.

Гүйлгээний дугаар:	P251111160245
1250217445295,47000912616,АЮ87022070,2605УБС,АМАРСАЙХАН ЭНХЗОРИГ,:	242,919 төгрөг
1250231613977,47000912616,АЮ87022070,2605УБС,АМАРСАЙХАН ЭНХЗОРИГ,:	150,000 төгрөг
Гүйлгээний нийт дүн:	392,919 төгрөг
Гүйлгээ хийсэн огноо:	2025/11/11 16:25:36



Авто тээврийн хэрэгслийн албан татвар,
төлбөр, төлсөн тасалбар

1. Эзэмшигчийн овог: Амарсайхан
2. Нэр: ЭНХЗОРИГ
3. ТТД: АЮ87022070
4. Тээврийн хэрэгслийн улсын дугаар: 2605УБС
5. 2025 оны албан татвар, төлбөр:

Утга

1 .АТБӨЯХТ

2 .АЗАТ

6. Албан татвар, төлбөр төлсөн огноо: 2025-11-11

Дүн

242,919

₮

150,000

₮



Зураг 2. Авто машины төлбөр төлсөн баримт

3.2 Усан орчны чиглэлээр

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажлуудыг төлөвлөж хийж гүйцэтгэсэн. Аймгийн байгаль орчны албаар ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, Алтанширээ сумын засаг дарга О.Ган-Одтой 08 сарын 26-ны өдөр ус ашиглах гэрээг байгуулж, Ус ашигласны төлбөрт 09 сарын 03-нд 3494636 төгрөг төлсөн.

Хүснэгт 2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Аймгаараа дүгнэлт гаргуулаад, сумтайгаа гэрээ байгуулж, төлбөрөө төлнө.	Уурхайн дарга	Дорноговь аймгийн Байгаль орчны газрын 2025.08.05-ны өрийн 34 тоот дүгнэлтийг үндэслэн Алтанширээ сумын засаг дарга О.Ган-Одтой 08 сарын 26-ны өдөр уст цэг ашиглах гэрээ байгуулж, 09 сарын 03-нд 3494636 төгрөг төлсөн. /Хавсралт 3, 4/
2	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх		Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасны дагуу уст цэгүүдэд холбогдох шинжилгээг 8, 11-р сард “Ногоон Эко Мандала” ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний үр дүнгээр стандартаас давсан үзүүлэлтгүй, өөрөөр хэлбэл бохирдолгүй байна.
3	Шүүрлийн усны шавхах хэсэг дээр тоолуур суурилуулна.		Далд уурхайн шүүрлийн усны шугам хоолойд тоолуур суурилуулж баталгаажуулсан. Шүүрлийн усны тоолуурыг “Инженеринг сервис” ХХК-аас тоолуураа худалдан авч суурилуулсан бөгөөд өвөл хөлдөлт үүсэх учир салгалт хийгдсэн. Тоолуурын үнэ 1000000 сая төгрөг.
	Нийт зардал		4494.6 төгрөг төлсөн.



Зураг 3. Шүүрлийн усны тоолуур

**“ӨМНӨ БАГА ЧУЛУУ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3.3 Хөрс, ургамал, амьтны чиглэлээр

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн дарга	Газар ашиглах гэрээний үүргийн дагуу газар эзэмших, ашиглах гэрээний биелэлтийг дүгнүүлж газар ашиглах Гэрээг Сумын засаг даргатай 10 сарын 01-ний өдөр байгуулсан. Газрын төлбөрт 3510000 төгрөг төлсөн. /Хавсралт 1/
2	Машины зогсоол шинээр бий болгож, талбайг цементлэх		Машины зогсоол шинээр бий болгож, талбайг цементлэх ажил хийгдсэн. Машины зогсоол 1240 м2 хэмжээтэй хийгдсэн. Нийт 900000 төгрөг зарцуулсан. /зураг 5/
3	ШТС-ын доод суурийг түлш, шатахуун асгарахаас сэргийлж суурийг цементлэх		ШТС-ын доод суурийг түлш, шатахуун асгарахаас сэргийлж 2025 оны 05-р сарын 26-ны өдөр суурийг цементэлсэн. Нийт 500000 төгрөг зарцуулсан. ШТС-ын суурийн хэмжээ нь 80м ² , /Зураг 4/
4	Байгаль орчны аудитын ажлын зөвлөмжийн дагуу ариун цэврийн байгууламжийн байршлыг сольж кемпийн салхины доод талд байршуулах.		Мөн бие засах газрын байршлыг сольж суурийг хүчитгэн хөрсөнд бохир нэвчихээргүй болгож хийсэн. /Зураг 3/
	Нийт зардал		4910.0 мян.төг



Зураг 4. Бие засах газрын байршлыг сольж шинээр доторлов /2025.10 сар /



Зураг 5. ШТС-ын суурийг цементлэв /05 сарын 26/

**“ӨМНӨ БАГА ЧУЛУУ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



Зураг 6. Авто зогсоолын суурийг цементлэв

**Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд
Хүснэгт 4. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах**

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Орд орчмын хөрсний судалгааг нарийвчлан, харьцуулалт хийх	Уурхайн дарга	2025 оны 8, 11-р сард хөрсний судалгааг хийлгэсэн. Итгэмжлэгдсэн Лабораторийн үр дүнгээс бүх цэг дээрх ялзмагийн агууламж 1.3-1.38% байна. Ялзмагийн агууламж бага хэмжээнд байна. Урвалын орчин сул шүлтлэг орчинг үзүүлж байна. Карбонат энэ 2 цэгт огт илрээгүй. Цахилгаан дамжуулах чадвар бүх цэг дээр бага буюу давсжилтгүй. Хөрсний үржил шимийн гол үзүүлэлт болох хөдөлгөөнт калийн хангамж бага хэмжээтэй байна. Хөдөлгөөнт фосфорын хангамж шимт хөрсний овоолгын цэгт маш бага, байгалийн хөрсөнд дундаж хэмжээнд байна. Хөрсний бохирдлын хувьд бүх цэгт стандартыг

**“ӨМНӨ БАГА ЧУЛУУ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

		давсан үзүүлэлт илрээгүй буюу бохирдолгүй. Хяналт шинжилгээ, мониторингийн зардалд орсон. 2 удаагийн орчны хяналт шинжилгээний зардал 10000000 сая төгрөг байна. /зураг 23, хавсралт
2	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байршуулсан.	Уурхайн хотхонд гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах унтраагуур 6 кг-2 ш, галын шланг 20 м-2 ш, галын хүрз-2 ш нэмж байршуулсан бөгөөд нийт 500.0 төгрөг зарцуулсан. Зургийг хавсралтаар оруулав.
	Нийт	10500.0 мян.төг



Зураг 7. Ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа /2025.08 сар/.



Зураг 8. Гал унтраах багаж хэрэгслийн зураг

3.4 Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлууд

Хүснэгт 5. Тэрбум мод хөтөлбөрийн биелэлт

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Тусгай зөвшөөрлийн талбайд 2025 онд 500 ш мод тарина.	Компанийн менежер	Тусгай зөвшөөрлийн талбайд хотхоны урд хэсэгт 500 ш хайлаас мод тарималжуулсан бөгөөд сайн ургаж байгаа. Модны ургалтыг сайжруулахын тулд Натри, кали, фосфорын бордоогоор бордсон. Ургалт 95 хувьтай ургасан.
	Нийт зардал		2000.0 мян.төг



Зураг 9. Мод тарьж байх үеийн зураг /2025. 06 сар/



Зураг 10. Модны ургалт болон бордоо



Зураг 11. Тэрбум модны ургалт /2025. 08 сар/

**“ӨМНӨ БАГА ЧУЛУУ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3.5 Дүйцүүлэн хамгаалах ажлын биелэлт

Хүснэгт 6. Дүйцүүлэх хамгаалах ажлын биелэлт





Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Дүйцүүлэн хамгаалах ажлаар сумын ногоон төгөлд усалгааны системийг суурилуулах.	Уулын инженер	<p>Алтан ширээ сумын төвийн хойд талд байрлах “Хөгнө цагааны ойн зурвас” нэртэй ногоон байгууламжийн талбайд дуслын усалгааны системийг шийдэж 5.0 сая төгрөг зарцуулсан.</p> 
	Нийт зардал		5000.0 мян.төг

“ӨМНӨ БАГА ЧУЛУУ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

Акт үйлдсэн өгнөө: 2025.07.01
 Хүлээлгэн өгсөн байгууллага: МАНДАХ ДОРНЫН ЖОНШ ХХК
 Хүлээн авсан байгууллага: АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Нарийн шланг 	м	8000
2	Будуун шланг 	м	300
3	Уян цагаан шланг 	м	200
4	Том холбогч 	ш	

保定润农节水灌溉
销货清单 0002892

客户: 2025年 6月16日

序号	品名及规格	单位	数量	单价	金额
1	滴灌带10mm 4寸	盘	4	143	572
2	90管 10厚	卷	3	145	435
3	90白色滴灌带	米	100	2.8	280
4	16号快速接头(含球)	个	200	0.3	60
5	90长箍加粗	个	60	0.9	54
6	90尼龙球阀	个	2	16	32
7	90三通球阀	个	4	15	60
8	90直接	个	3	2	6
9	90弯头	个	3	3	9
10	拉环直接	个	100	0.1	10
11	螺帽打扎器	个	3	5	15
12	90四通三通	个	4	31	124
13	90四通双球阀	个	4	20	80
14	90三通双球阀	个	4	20	80
15					共 1817

合计(大写) 拾万仟佰拾元角分

制单: 贾建强 电话:

Зураг 12. Дүйцүүлэн хамгаалах ажил

3.6 Нөхөн сэргээлтийн биелэлт

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн биелэлт

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	2025 онд өмнө ил аргаар эвдэрсэн 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.	Уулын инженер	2025 онд тусгай зөвшөөрлийн талбайд ил уурхайн үйл ажиллагаагаар өмнө эвдэрсэн 2.1 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн стандарт 5914:2008”-ын дагуу түрж тэгшлэн хийсэн. Маркшейдэрийн тайлангийн хэмжилтээр баталгаажиж байгаа бөгөөд тус тайлангийн өртөг 10.0 сая төгрөг.
	Нийт зардал		10000.0 мян.төг



Зураг 13. Техникийн нөхөн сэргээлтийн үеийн зураг

“ӨМНӨ БАГА ЧУЛУУ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн №01 Актын хавсралт

НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ТАЛБАЙН ЗУРАГ



ЭВДЭРСЭН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ

2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр

1. Байршлын мэдээлэл	
1.1. Аймаг, нийслэлийн нэр	Дорноговь аймаг
1.2. Сум, дүүргийн нэр	Алтанширээ сум
1.3. Газрын нэр	Цагаан дал
2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын мэдээлэл	
2.1. Нөхөн сэргээлт хийсэн аж ахуй нэгжийн нэр, регистр	"Мандах дорнын жонш" ХХК 9011300024 улсын бүртгэлтэй, регистр № 5497272
2.2. Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Өөрийн хөрөнгө
2.3. Тус газрын эвдрэлд өртсөн шалтгаан	Хууль бус олборлолтонд өртсөн талбай
2.4. Тус талбайд нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ (га)	2,1 га
2.5. Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрхтэй эсэх, зөвшөөрлийн дугаар	
3. 2025 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл	
Нөхөн сэргээлтийн арга	Техникийн нөхөн сэргээлт
- Талбайн хэмжээ (га)	MV-021637 тоот Мандах дорнын жонш ХХК нь 9,2 метрын гүнтэй, 8,5 метрийн өргөнтэй, 272 метрийн урттай, 212770,4м ² эзлэхүүнтэй талбайн техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн байна.
4. Орон зайн мэдээлэл	
4.1. Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг	Хавсралтаар нөхөн сэргээлт хийсэн газрын зургийг хавсаргав.
4.2. Хэмжилт, зураглал	- Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр: Эн Си Эй ХХК-ийн инженер Г.Алтангарал

4.3 Нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол		
	Х	У
1	473072.7573	5066427.923
2	473072.9242	5066423.031
3	473248.6819	5066298.059
4	473249.323	5066291.287

Жич: 4-өөс доошгүй эргэлтийн цагийн солбицол байна.

5. Мэдээллийн сангийн бүртгэл	
Нөхөн сэргээлтийг хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээллийн сангийн www.eis.mn цахим системийн Нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ.	
Жич: Мэдээллийн санд бүртгээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийг хүлээн авсан актыг хүчинтэйд тооцохгүй.	
Огноо: 2026.01.09	
Нэмэлт мэдээлэл: Хавсралтаар нөхөн сэргээлт хийсэн газрын зургийг хавсаргав.	

Дүгнэлт:

1. Тус аж ахуйн нэгж нь тухайн талбайд хууль бус олборлолтонд өртсөн байсан ухашийг нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэсэн.
2. Тус аж ахуйн нэгж нь нөхөн сэргээлтийн ажиллагааны явцад зохиох хууль тогтоомжийг мөрдөж ажилласан болно.
3. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны явцад хяналт тавьж ажилласан.
4. Нөхөн сэргээлт хийсэн газрыг сумын Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2026 оны 01 дугаар сарын 09-ны өдрийн 11⁰⁰ цагаас 15⁰⁰ цагийн хооронд газар дээр нь шалгаж уг газрыг хүлээн авсан.

Акт гаргасан:

Ажлын хэсгийн ахлагч:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ
ТОЙГ БАГИЙН ЗАСАГ ДАРГА
ХЭСГИЙН ТӨЛӨӨЛӨГЧ
ИРГЭНИЙ ТӨЛӨӨЛӨЛ

Ө.УНДАРМАА
Т.ГЭГҮҮН
Э.БАЯРЖАРГАЛ
Н.БАЯРСАЙХАН

Хүлээлгэн өгсөн:

"МАНДАХ ДОРНЫН ЖОНШ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.БАТМАГНАЙ

Зураг 14. Нөхөн сэргээлт хүлээлгэж өгсөн акт

**“ӨМНӨ БАГА ЧУЛУУ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Д/Д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Ахуйн хатуу хог хаягдлыг сумын ТҮК-тэй гэрээ байгуулан зөөвөрлөх	Уурхайн дарга	Хог хаягдлын гэрээг 2025 оны 08-р сарын 11-нд Алтанширээ сумын засаг дарга О.Ган-Одтой байгуулсан. Хог хаягдлын төлбөрт нийт 5553000 төгрөг тушаасан. Сард 0.5 тн, нийт 3.5 тн хог хаягдал цуглуулж сумын хогийн цэгт хаясан.
2	Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.		Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж байсан. Шил лааз, дахин ашиглах гэсэн 3 ангилсан хог хаягдлын цэг байгуулсан. Шил лааз нь 25 кг-ийн шуудайгаар 8 ш буюу 200 кг, цаасан болон бусад хог хаягдал хэдэн 25 кг гарсан.
3	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах		Хог хаягдал түр хадгалах 6.2 м2 талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулсан. 500000 төгрөг.
4	Ахуйн хог хаягдлаа цэвэрлэх зорилгоор уурхай орчмын талбайд их цэвэрлэгээ хийж орчин тойрноо цэвэрлэнэ.		Уурхайн их цэвэрлэгээг улиралд 1 удаа хийж байсан. Үүнд тусгай зөвшөөрлийн талбайн 219.4 га талбайг хамарсан цэвэрлэгээ хийгдсэн ба 200 кг хог хаягдал гарсан.
5	Уурхайд ашиглаж буй машинаас гарсан хаягдал тос, маслог зориулалтын цэгт хуримтлуулах, дугуй ламп гэх мэтийг дахивар авах газарт тушаана.		Зориулалтын саванд хадгалсан. Хаягдал тос 100 орчим л гарсан бөгөөд үүнийг далд уурхайн тороосны тосолгоонд хэрэглэдэг учир буцаан ашиглагддаг. Хаягдал дугуй гараагүй. Акумуляторыг завсарын газар солиулсан.
Нийт зардал			6053.0 мян.төгрөг



Зураг 15. Хог хаягдлын цэг байгуулсан байдал



Зураг 16. Их цэвэрлэгээ хийгдэж буй байдал



Зураг 17. Хог ангилан ялгаж буй байдал

3.8 Осол эрсдэлийн менежментийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд

Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын биелэлт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт, зарцуулсан зардал
Үйлдвэрийн аваар осол, саатал гэмтлээс шалтгаалан ажилчид бэртэж гэмтэх, хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэлтэй,	Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн зөвлөмжийг боловсруулж, ажилчдад сургалт явуулах.	“Далд уурхайн ерөнхий мэдлэг олгох, аюулгүй ажиллагаанд сургах, ажлыг хэрхэн аюул эрсдэлгүй явуулах, эрсдэлийг хэрхэн яаж удирдах болон Монгол улсын ХАБЭА-н хуулийг дагаж ажиллах” нэртэй сургалтыг улиралд 1 удаа нийт 4 удаа явууллаа. сургалтыг ХАБЭА-ийн мэргэжилтэн Г.Мөнгөншагай удирдан явуулж, Заавар зөвлөгөө өгч ажиллаж байв. 40-43 ажилчид тогтмол хамрагдсан.
	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	2025 оны 6-р сарын 3-нд сумын эмч ирж үзлэг хийн 15 ажилтан хамрагдсан бөгөөд даралт, нүд, цээж чагнаж үүнээс 7 ажилтан 5 хоногийн эмчилгээ хийлгэсэн, эм болон дусал тариа сумын эмнэлэгт өдрөөр очиж үйлчлүүлсэн. Үүний төлбөр 402000 төгрөг зарцуулав.
	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж хөдөлмөр хамгааллын 10 ш малгай, 20 ш бээлий, 20 ш хошуувч, 10 ш усны гутал, 10 ш хантааз зэрэг нийт 5 төрлийн 70 ширхэг хувцас, багаж хэрэгслээр хангаж байв.
	Анхны түргэн тусламжийн багаж, эмээр хангах	Анхны түргэн тусламжийн 63 нэр төрөл бүхий даралтын аппарат, тариур, дуслын систем болон эмээр хангаж үүний зардал нь 3264500 төгрөг болов.
	Анхны түргэн тусламжийн сургалтад хамруулах	Ажилчдын хотхонд анхны түргэн тусламжийн сургалтыг сумын эмнэлэгтэй хамтран зохион байгуулж 15 хүн хамрагдсан. Үүний үр дүнд уурхайн ажилчид анхны түргэн тусламжийн талаар мэдлэг мэдээлэлтэй болсон.
Нийт зарцуулсан зардал		3666.5 мян.төг



Зураг 18. Сумын эмнэлэгтэй хамтран ажилчдыг эмнэлгийн анхан шатны үзлэгт хамруулав /2025 оны 4-р сар/



Зураг 19. Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт тогтмол явуулж байв /2025 оны 4 сар/



Зураг 20. Хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгсэл авсан байдал

3.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажилласан.

Хүснэгт 10. удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

